



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

Чингис хот

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 160

Г Хагас жилийн мал тооллого явуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2025 оны 06 дугаар сарын 04-өөс 2025 оны 06 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулсугай

2. 2025 оны хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Комиссын дарга:	А.Боргил – Хэрлэн сумын Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Ж.Алтантөгс – Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Г.Цэрэнтогтох – Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
	Б.Эрдэнэбилэг – Хэрлэн багийн Засаг дарга
	Б.Отгонбаатар – Булаг багийн Засаг дарга
	Б.Мөнхбаяр – Баянмөнх багийн Засаг дарга
	Ё.Баяртулга – Сариг багийн Засаг дарга
	А.Мөнх-Эрдэнэ – Өндөрхаан багийн Засаг дарга
	Д.Мөнхтуяа – Цогт-Өндөр багийн Засаг дарга
	Д.Алтаннараа – Номгон багийн Засаг дарга
	Д.Отгонцэцэг – Номгон багийн төрийн сангийн мэргэжилтэн
	Ө.Зоригт – Ишгэн толгой багийн Засаг дарга
	Д.Сандагдорж – Мал эмнэлгийн тасгийн дарга, Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч

3. Хагас жилийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарь гарган, дүн нэгтгэлийг 06 дугаар сарын 13-ны дотор сумын комиссын хурлаар хэлэлцүүлэн аймгийн статистикийн хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (А.Боргил)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР

D:\Албан тоот 2015\Zahiramj\Захирамж 2015.doc

231110370